



2.3. Үйлдвэрийн орчны аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхийг шаардах.

2.4. Хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх.

2.5. Уурхайд шаардлагатай үед Хүн эмнэлэг, соёлын болон цагдаагийн үйлчилгээг үзүүлэх.

2.6. "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ нь уул уурхайн төслийг хэрэгжүүлэн ажилладаг учир Монгол улсын газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд сумын ИТХ-аар холбогдох шийдвэрийг гаргуулахад хуулийн хүрээнд холбогдох журмын дагуу дэмжлэг үзүүлэх.

#### Гурав. УБҮ-ийн хүлээх эрх, үүрэг

3.1. Монгол Улсын хуулийн дагуу албан татвар, хураамжийг хугацаанд нь төлж тайлагнах, татварын өр төлбөргүй ажиллана.

3.2. Үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр 2,0 сая.төг

3.3. Хөдөлмөр эрхлэлт ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:

Ногоон байгууламжид ажиллах 3 иргэнийг урамшуулж цалинжуулах  
15,84 сая.төг

3.4 Мод суулгацаар хангах чиглэлээр 10,0 сая.төг

3.5 Соёлын өвийг хамгаалах чиглэлээр 10,0 сая.төг

3.6 Ногоон байгууламжийн усалгааны систем, булаг шандын эхийг хамгаалах, хөв цөөрөм байгуулах гэх мэт бүтээн байгуулалтын чиглэлээр  
27,0 сая.төг

3.7 Хог хаягдал түрэх, хогийн цэгийн ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр  
12,6 сая.төг

**Нийт 77,44 сая.төг**

#### Дөрөв. Гэрээний хариуцлага

4.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

4.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гарган ажиллана.

4.2. Талууд бичгийн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

4.3. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарах, эсхүл цуцлах тохиолдолд талууд бие биедээ 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

4.4 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь хуулийн этгээдийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### Тав. Маргаан шийдвэрлэх

5.1 Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоо маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

5.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Гэрээ дүгнэх

6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Давагдагшгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

6.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.3. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"БОР-ӨНДӨР" УБУ-ИЙН БОНСХ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХХҮЛЭГЧ

Утас: 85000111

"БОР-ӨНДӨР" СУМЫН ЗДТГ-ЫН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙЦААГЧ

Э.ОТГОНТУНГАЛАГ

Утас: 99137733

ТАНИЛЦСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ЗХ-ИЙН ДАРГА

ЕРӨНХИЙ НЯ-БО

ТЭЗСХ-ИЙН ДАРГА

ХУУЛЬЧ

П.МАШБАТ

Ж.ЦОГТБААТАР

Д.ОНОН

Б.ИДЭРБАЯР

Ж.ЖАВХЛАН-ЭРДЭНЭ